



БҮРЭЛДЭХҮҮН, ХАРЬЯА СУРГУУЛЬ,  
ХҮРЭЭЛЭН, КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ,  
ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА НАРТ

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛЬ**

Бага тойруу 34, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191  
Утас: 32 51 09, 32 47 09, Факс: (976-11) 32 41 21,  
Цахим шуудан: administration@must.edu.mn,  
Цахим хуудас: www.must.edu.mn


2025.03.19 № 3/156  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Эрдмийн чуулган-2025 хуралд  
оролцуулах тухай**

Шинжлэх ухаан, технологийн их сургуулиас профессор, багш, судлаачдын гүйцэтгэж буй эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг нийтэд танилцуулан хэлэлцүүлэх, харилцан туршлага солилцох, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий “ЭРДМИЙН ЧУУЛГАН - 2025” эрдэм шинжилгээний нэгдсэн хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж байгаа тул бүрэлдэхүүн, харьяа сургууль, хүрээлэнгүүд тус тусын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, профессор, багш, судлаачдыг өргөнөөр оролцуулан шалгарсан илтгэлүүдийг ирүүлж хамтран ажиллахыг хүсье.

Эрдэм шинжилгээний хурлын удирдамжийг хавсаргав.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ  
ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР



Д.ЦОЛМОНБААТАР

367060313

БАТЛАВ:



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ  
ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР Д.ЦОЛМОНБААТАР

## “ЭРДМИЙН ЧУУЛГАН-2025” ПРОФЕССОР, БАГШ, СУДЛААЧДЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

**Зорилго:** Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн профессор, багш, судлаачдын гүйцэтгэж буй эрдэм шинжилгээ, судалгааны ажлын явц болон үр дүнг хэлэлцүүлэх, харилцан туршлага солилцох, олон нийтэд таниулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх.

**Хамрах хүрээ:** ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харьяа сургууль, хүрээлэн, коллежийн профессор, багш, судлаачид.

### Хугацаа, үе шат:

**I шат:** Бүрэлдэхүүн болон харьяа сургууль, хүрээлэн, коллеж 2025 оны 4 дүгээр сарын 21-ний дотор профессор, багш судлаачдын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, шалгарсан 3 илтгэлийн материалыг Эрдэм шинжилгээ, технологи хөгжүүлэлтийн албанд ирүүлнэ.

**II шат:** Профессор, багш судлаачдын “Эрдмийн чуулган 2025” эрдэм шинжилгээний нэгдсэн хурал 2025 оны 4 дүгээр сарын 30-ний өдөр ШУТИС-ийн VIII байрны 12 давхрын “Хурлын танхим”-д зохион байгуулагдана.

### Эрдэм шинжилгээний салбар хуралдаан:

- Техник-технологи;
- Байгалийн ухаан, хэрэглээний шинжлэх ухаан;
- Нийгэм, эдийн засаг, дизайн;

### Нийтлэг шаардлага:

- ✓ Сүүлийн 3 жилд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн байх;
- ✓ Урьд өмнө хэвлэн нийтлэгдээгүй бүтээл байх;
- ✓ Сэдвийн хүрээнд тулгамдаж буй асуудлыг дэвшүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон, баримт нотолгоонд тулгуурласан, шинэлэг санаа, практик ач холбогдол, түүний хэрэгцээг тодорхойлсон дүгнэлттэй байх;

- ✓ Бүтээлд гадаад, дотоодын эх сурвалжийг ашигласан байх, бусдын бүтээлийг ашиглахдаа эх сурвалжийг заавал дурдсан байх;
- ✓ Бүтээлийн хуулбарлалт шалгах программаар шалгаж өгүүлэл тус бүрээр хуулбарлалтын (PDF) тайланг татаж ирүүлэх; Хуулбарлалтын тайлангийн загвар харах: <https://research.must.edu.mn/page/135>
- ✓ I шатанд хэлэлцүүлж шалгарсан бүтээл байх /Бүрэлдэхүүн сургуулийн захирлын албан бичгээр баталгаажуулах/;
- ✓ ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих зааврыг баримталж бичсэн байх; /<https://research.must.edu.mn/page/104/>

Бүрэлдэхүүн болон харьяа сургууль, хүрээлэн, коллеж тус бүрээс II шатанд оролцох 3 шилдэг илтгэлийг 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн дотор Эрдэм шинжилгээ, технологи хөгжүүлэлтийн албанд хэвлэмэл болон (word) файлаар [research@must.edu.mn](mailto:research@must.edu.mn) цахим хаягаар захирлын албан бичгийн хамт ирүүлнэ.

#### **Шилдэг илтгэлд олгох грант:**

- Техник-технологи
  - I байр - Батламж, 1,5 сая төгрөг
  - II байр - Батламж, 1,0 сая төгрөг
  - III байр - Батламж, 800 мян.төгрөг
- Байгалийн ухаан, хэрэглээний шинжлэх ухаан
  - I байр - Батламж, 1,5 сая төгрөг
  - II байр - Батламж, 1,0 сая төгрөг
  - III байр - Батламж, 800 мян.төгрөг
- Нийгэм, эдийн засаг, дизайн
  - I байр - Батламж, 1,5 сая төгрөг
  - II байр - Батламж, 1,0 сая төгрөг
  - III байр - Батламж, 800 мян.төгрөг

#### **Бүтээлийг нийтэд түгээн дэлгэрүүлэх:**

Хуралд хэлэлцүүлсэн илтгэлийн эмхэтгэлийг Эрдэм шинжилгээ, технологи хөгжүүлэлтийн албанаас эрхлэн гаргаж, олны хүртээл болгох, таниулах ажлыг зохион байгуулна.